



**НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

᠒᠐᠒3 оны 02 сарын ᠒᠐ өдөр

Дугаар ᠑/᠒4

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/121 дүгээр захирамж, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/121 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, шийдвэрийг мөрдөн ажиллаж, үр дүнг тайлагнахыг Үнэлгээний хорооны дарга (Н.Энхбаяр)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Т.Оргил-Эрдэнэ)-т даалгасугай.


4. Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Оюунбилэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2023 оны 02 дугаар сарын 02-ны
өдрийн 20/14 дугаар тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА: Н.ЭНХБАЯР
(НХОГ-ын Барилга
захиалагчийн хэлтсийн
Ахлах инженер)

ГИШҮҮД: Т.БАТЗАЯА
(НЗДТГ-ын Хүний нөөцийн
хөгжлийн төвийн менежер)

Ж.СОЛОНГО
(НХОГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн
Хөрөнгө оруулалтын санхүүжилт
хариуцсан мэргэжилтэн)

Я.АЛТАНТУНГАЛАГ
(Хан-Уул дүүргийн 2 дугаар
хорооны иргэн)

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: Д.ОЮУНБИЛЭГ
(НХОГ-ын Мэдээллийн
технологийн хэлтсийн
Системийн мэргэжилтэн)